

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2017 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ**

2017.11.09

ӨЛГИЙ

Д/д	7 хоногийн ажлын товч мэдээлэл
01	<p>Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны хяналтын тооллого хийх Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Ерөнхий газрын даргын А/288 туушаалын хүрээнд 2017 оны 11-р сарын 6-ны өдрөөс 8 өдөр хүртэл ХХҮЕГазраас Н.Баттөгс, Ц.Дүгэрмаа нар Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээллийн сангийн шинэчлэлтийг хэрхэн хийж гүйцэтгэснийг эх үүсвэрүүдэд үндэслэн тулган шалгаж, өрхийн оноо бодогдсон, сонгондсон өрхүүдэд түүвэрлэн зочилж үр дүнг тулган шалгаж, аливаа гарсан асуудлууд болон тодорхой бус асуудлаар зөвлөмж өгч ажиллав. Толбо сумын Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцав. Сумын төв болон 2, 3 дугаар багийн нийт 8 өрхөд зочилж асуулгын маягт бөглөв. Аймгийн төвийн 6 багийн 36 өрхөд зочлов. Мөн судалгааны мэдээлэл цуглуулт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлт, архивлалтыг батлагдсан заавар аргачлалын дагуу гүйцэтгэн ажилласан ажлын гүйцэтгэлийг харьцуулан шалгаж, үнэлгээ өгч ажиллав.</p>
02	<p>Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон ба чанарын судалгаа хийх арга зүй сэдэвт сургалтыг 13 сумын засаг дарга нар болон хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Засаг даргын захирамжаар баталсан ажлын хэсэг, ажил олгогч нарт 11-р сарын 7,8 өдрүүдэд зохион байгуулав. Нийт 85 хүн сургалтанд хамрагдав. Мөн Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх бэлтгэл ажил хангаж судалгааны асуулгын маягтуудыг эцсийн байдлаар баталгаажуулав. Аймгийн засаг даргын захирамжаар баталсан ажлын хэсгийн төлөвлөгөөг зохиож, сумуудад судалгаа авах ажлын хэсэг томилж, судалгаанд явах маршрут зэргийг бэлдэв.</p>
03	<p>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн ахмадын зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд шинээр 35 ахмадуудад гэрээ хийж үйл ажиллагаанд хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг цаг тухайд нь авав.</p>
04	<p>Хөдөлмөрт бэлтгэх, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд “үйлдвэр дээрх сургалт” зохион байгуулах арга хэмжээнд Файнноос ХХК-ийг хамруулж, тухайн компанид ажиллах сонирхолтой 26 ажилгүй иргэнийг сургалтанд хамруулж, сургалтын явцад хяналт тавьж ажиллаж байна. Мэргэжлийн түр сургалтыг барилгын засал чимэглэл, санхтехник, касс-нярав, зочид буудлын үйлчлэгч зэрэг мэргэжлээр зохион байгуулахаар төлөвлөж, ажил олгогч нарт захиалгын хуудас явуулан, радио, телевизээр зарлав. Нийт -31 иргэн бүртгүүлээд байна.</p>
05	<p>Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд иргэдийн хүсэлт, төслийг хүлээн авч 10 иргэнтэй гэрээ байгуулан, санхүүгийн дэмжлэгийг олгож ажиллав. Шинээр 18 ажлын байр бий болов.</p>
06	<p>2016-онд Аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн дэд хөтөлбөрийг зарлан зохион байгуулж, хувиараа бизнес эрхэлж буй залуучууд болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хамруулж 20 иргэнд санхүүгийн дэмжлэг олгохоор аймгийн ЗД-ийн захирамжаар батлуулав.</p>
07	<p>ХЭБ-ийн олголтын тайланг сумуудаас авч нэгтгэн, 1-10-р сарын ХЭБ-ийн олголтыг програмид шивж оруулсан. 10-р сарын цаасан хүнсний эрхийн бичгийг 13 суманд хувиарлан өгсөн. ӨАТТС-ны хяналтын тооллого хийх чиглэлээр Хөдөлмөр,халамжийн ерөнхий газраас ХШҮ мэргэжилтэн Н.Баттөгс, ХТДТХ мэргэжилтэн Ц.Дүгэрмаа нар Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлтийг хэрхэн хийж гүйцэтгэснийг эх үүсвэрээс тулган шалгаж, 292 онооноос доогуур бодогдсон өрхүүдэд түүвэрлэн зочилж, өрхүүдээс асуулга авч ажилласан. Тодорхой бус асуудалд зөвлөлөгөө өгч ажиллав. ХХҮЕГ-ын ирсэн удирдамжийн дагуу 292 онооноос доогуур байгаа Өлгий сумын 13-р багийн 8 өрхөд орж баталгаажуулалтын судалгаа авсан болно. Эдгээр өрхүүд үнэхээр эмзэг бүлгийн ХЭБ-т хамрагдах шаардлагатай өрхүүд байсан. Өрхийн мэдээллийн сангаас туулган шалгахад ямарч зөрүү гараагүй байсан. НХҮЕГ-аас ирсэн мэргэжилтэнүүд судалгааны мэдээлэл</p>

	цуглуулалт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлт, архивлалтыг батлагдсан зааврын аргачлалын дагуу ажилласан ажлын гүйцэтгэлийг харцуулан шалгаж, үнэлгээ өгч ажилласан.
08	Өрхийн Мэдээллийн Нэгдсэн Сантай холбоотой шинээр төрсөн хүүхэд бүртгүүлэх тухай 12 өргөдөл, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах тухай 1 өргөдөл тус тус хүлээн авч иргэдэд цаг тухайд нь хариу өгч ажиллав. Мөн Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээллийн сан, мэдээлэл цуглуулалт, өрхийн оноо бодсоны дараах үр дүнг харьцуулах хяналтын тооллого хийх тухай удирдамжийн дагуу Өлгий сумын 3 дугаар багийн сонгогдсон өрхүүдэд зочилж судалгаа авч, өмнөх асуулгын хуудас болон мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулгалт хийв.

**МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА ГАРГАСАН:
ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА**

Д.АЛТЫНГҮЛ